

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

2024 оны 06 дугаар сарын 14

Багануур дүүрэг

2023 онд Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг батлан, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж, нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийг нэвтрүүлэн ажилласан онцлог жил болж байна.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь тайлант хугацаанд шинээр мөрдөгдөж буй Нийгмийн даатгалын багц хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан Нийгмийн даатгалын тухай хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн захиргааны удирдах дээд шатны байгууллагуудаас гаргасан тушаал, захирамж, тогтоол, шийдвэр, албан даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Тайлант хугацаанд ажил олгогч даатгуулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалж, хууль дээдлэн, бусдын нөлөөнд үл автан ажиллах зарчмыг баримтлан, дүүргийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын хуулийг хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг зохих сангаас, хуулиар тогтоосон цаг хугацаанд тогтоон, шинээр нэвтрүүлж буй Sicos цахим системээр бүртгэж олгосон.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/61 дүгээр тушаалаар тайлант оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил” болгон зарласны дагуу ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулах ажлын төлөвлөгөөг баталсны дагуу хамралтыг нэмэгдүүлэх, шимтгэлийн өр авлагыг бууруулах чиглэлээр анхааран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тус хэлтсийн 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан нийт 46 зорилт, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үүнд:

| Д/д | 0-30 | 31-69 | 70-99 | 100 | Дундаж үнэлгээ |
|-----|------|-------|-------|-----|----------------|
| 1   | 2    | 3     | 25    | 16  | 88,2           |

## **Давуу тал:**

### **Орлогын төлөвлөгөө**

2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийгмийн даатгалын санд нийт 13547230,3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 18034424,1 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 133,1%-аар биелүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж болон хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, 2024 оноос эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийг ЭМДЕГ-т төвлөрүүлэх болсноор тус газар иргэдийн шимтгэл төлөлтийг шалгаж, мэдээлэл өгөх, шимтгэлээ цахим хэлбэрээр төлөх заавар, зөвлөгөөг өгч ажиллалаа. Албан журмын даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалын шимтгэл 3305,1 сая төгрөгийн орлогыг холбогдох санд төвлөрүүлсэн байна.

Тайлант онд тус газар нь 30 ажил олгогч, 195 албан журмын даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулахаар төлөвлөснөөс 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22270,0 мянган төгрөгийн цалингийн сантай 17 ажил олгогчийн 39 даатгуулагчийг нийгмийн даатгалд шинээр хамруулсан байна.

Сайн дурын даатгалд шинээр 264 даатгуулагчийг хамруулахаас 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 200 даатгуулагчийг хамруулж төлөвлөгөөг 75,8 хувиар биелүүлээд байна. Шинээр хамруулсан сайн дурын даатгуулагчдыг төрлөөр нь ангилбал малчин 38, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 18, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх /эцэг/ 20 хамрагдсан байна.

2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 5404 хүнд 25508.81 сая төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 159 хүнд 1055.33 сая төгрөгийн, нийт 5563 хүнд 26564.14 мянган төгрөгийг тэтгэврийг олгосон байна.

2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд 5654 тэтгэвэр авагчид үйлчилгээ үзүүлсэн байна. Тэтгэврийн төрлөөр ангилбал:

| Тэтгэврийн төрөл/                      | Өндөр насны тэтгэвэр | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр |
|--|----------------------|-------------------------------------|----------------------------|
| Тэтгэвэр авагчийн тоо                  | 4736                 | 594                                 | 233                        |
| Сард олгох тэтгэврийн хэмжээ /мян.төг/ | 4084.31              | 425.78                              | 155.83                     |

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 1248 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 258 даатгуулагчийн жирэмсэн, амаржсаны тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авсан. Мөн нас барсан 47 даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн баримтыг шалган, хүлээн авч, мэдээллийн баазад оруулж, мэдэгдэл бичиж олгуулсан. Ажилгүйдлийн даатгалын сангаас шинээр 70 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийн олголтыг нэгдсэн сангаас мэдээллийн үндэслэлийг тулган шалгаж шийдвэрлэсэн байна.

### **Цахим мэдээлэл**

Нийгмийн даатгалын байгууллагын архиваас олгоход баримтлах зөвлөмжийн дагуу архиваас олгох лавлагааны үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлж байна. Иргэд,

даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг хэлтэст биечлэн ирж хүсэлт гаргасан 199 иргэдэд, <http://app.ndaatgal.mn/> программаас 146, бусад аймаг дүүргүүдээс ирүүлсэн хүсэлт 136 лавлагааг олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг хэлтэс хооронд иргэдийг явуулалгүй гаргуулахад онцгойлон анхаарч, Үндэсний төв архив, аймгийн архивын тасгаас авах лавлагааны хүсэлтийг цахимаар гаргаж болох талаар зөвлөж, хэрхэн хүсэлт илгээхийг зааварлан ажиллаж байна.

Нийгмийн даатгалын архивын ажлын зааварт заасны дагуу иргэд, даатгуулагчид үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх, хэлтсүүд хооронд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг ажлын 3 хоног дотор солилцох ажлыг зохион байгуулж хэвших гэсний дагуу тус газраар дамжуулан бусад хэлтсээс архивын лавлагаа авах даатгуулагчдын хүсэлтийг Able программаар дамжуулан илгээж байна.

2006 оноос хойших лавлагааг local.ndaatgal.mn программаас олгодог болсноор иргэдийн цаг, хугацааг хэмнэж байна.

Архивын лавлагаа авах 461 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнд:

| № | Лавлагаа олгосон төрөл   | Тоо        |
|---|--|------------|
| 1 | Хэлтэст биечлэн ирж хүсэлт гаргасан иргэдэд олгосон лавлагаа   | 199        |
| 2 | Бусад аймаг, дүүргийн хэлтэст уламжилсан, хэлтсүүдээс хүсэлт ирүүлсэн                                      | 136        |
| 3 | <a href="http://local.ndaatgal.mn/">http://local.ndaatgal.mn/</a> > программаас олгосон QR кодтой лавлагаа | 16         |
| 4 | <a href="http://app.ndaatgal.mn/">http://app.ndaatgal.mn/</a> > нэгдсэн сүлжээний лавлагаа                 | 146        |
|   | <b>Нийт</b>  | <b>497</b> |

Дараах арга хэмжээнүүдийн биелэлт хангагдсан болон цаг үеийн нөхцөл байдлын улмаас удааширсан байна.

#### **Зорилт, арга хэмжээ 2.1.1:**

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөн ажиллаж нийгмийн даатгалын санд 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 21339,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 157,1 хувиар давуулж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 23075,2 сая төгрөг зарцуулж 1263,2 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

#### **Зорилт, арга хэмжээ 2.1.5:**

Тус газар нь тайлант оны шимтгэлийн авлагын эхний үлдэгдэл 9,592,125.4 мянган төгрөгөөс тайлант хугацаанд 5,119,759.97 мянган төгрөг буюу 53,4 хувийг барагдуулж, 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,472,365.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь Багануур ХК-ийн тайлант оны шимтгэлийн авлагын эхний үлдэгдлийг 6,093,445.3 мянган төгрөгөөр буюу 73,5 хувиар бууруулж, 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2024 оны 04, 05 дугаар сард ногдох 2,193,068.96 мянган төгрөгийн үлдэгдэлтэй боллоо. Энэ нь тус газрын нийгмийн даатгалын шимтгэлийн нийт авлагын 49 хувийг эзлэж байна.

Шимтгэлийн авлагыг барагдуулснаар тус компанийн ажилтан, даатгуулагч нар тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаандаа бүрэн гүйцэд авах нөхцлийг бүрдүүлэн ажилласан байна.

### **Зорилт, арга хэмжээ 2.1.7:**

1. Нийгмийн даатгалын сангийн авлага 2023 оны жилийн эцсээр 525,1 сая төгрөг байснаас 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 524,0 сая төгрөг болж 1,1 сая төгрөг төлөгдсөн. Тайлант хугацаанд оны эхний авлагын дүнгийн 493,0 сая төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллага (Цагдаагийн хэлтэс)-д шалгагдаж байгаа тэтгэврийн үлдэгдэл нийт авлагын 94%-ийг эзэлж байгаатай холбоотой байна.

2. Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор нийслэлийн алслагдсан 3 дүүргийн төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгох мөн байгууллагын бүтэц өөрчлөгдөж удирдах албан тушаалтнуудын албан тушаалын зэрэглэл өөрчлөгдсөн зэргээс үүдэн нийгмийн даатгалын шимтгэл, татварын суутгалтай холбоотой 4,1 сая төгрөгийн өр тайлант оны 05 сарын байдлаар үүссэн байна. Цалингийн судалгаа, холбогдох мэдээллийг НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт хүргүүлсэн байна. Үйл ажиллагааны бусад зардалд өр, авлага үүсээгүй байна.

### **Зорилт, арга хэмжээ 3.2.2:**

Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд хамтран ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд Хилийн цэргийн 0252 дугаар ангийн албан хаагч, үйлчилгээний ажилтны ээлжийн амралтын цалинг нийт дүнгээр тайлагнасан, эмэгтэй цэргийн албан хаагч болон үйлчилгээний албан хаагчдын жирэмсний болон амаржсан хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл төлөлтийг холбогдох баримтыг үндэслэн шалгаж цэргийн албан хаагч нэг эмэгтэй, энгийн албан хаагч 4 даатгуулагчийн жирэмсэн амаржсаны амралттай байсан хугацаа, хүүхэд асрах чөлөөтэй хугацааны эрүүл мэндийн даатгалын болон нийгмийн даатгалын шимтгэл нийт 349,2 мянган төгрөгийг, түүнд ногдох 174,5 төгрөгийн алдангийн хамт нөхөн төлүүлэхээр тогтоосон улсын байцаагчийн актын оны эхний үлдэгдэл нийт 523,7 мянган төгрөг төсөв шийдэгдээгүйгээс тайлант хугацаанд барагдаагүй байна. Хагас жилээр бүрэн барагдуулахыг мэдэгдэв.

### **Сул тал:**

Шинэ багц хууль, түүнийг хэрэгжүүлэх чиглэл, зөвлөмж, холбогдох тогтоол, журам, заавартай бүрэн танилцаж ажиллаагүй, мөн оны эхнээс шинээр нэвтрүүлж буй Sicos системийн хөгжүүлэлтийн явц байдал, байцаагч ажилтнуудын тус системд нэгдсэн ойлголтгүйгээр ажиллаж эхэлсэн байдлаас процессын болон тооцооны алдаа гаргах тохиолдлууд, үүнээс үүдэн иргэд, даатгуулагчдын өргөдөл, хүсэлт шийдвэрлэлт удаашралтай байна. өдөр тутам үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэвшүүлэн ажиллахыг Хуримтлагдсан өр авлагатай ажил олгогч, улсын байцаагчийн актаар тогтоогдсон авлагыг бууруулах талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажилласан боловч цаг үеийн нөхцөл байдал болон тус хэлтсээс үл хамаарах шалтгааны улмаас өр авлага барагдуулалт удаашралтай байна.

### **Зөвлөмж:**

Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомж, журам, дүрэм, чиглэл, зөвлөмжтэй нийт ажилтан, албан хаагчид бүрэн танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжилтийг анхаарч,

гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээнүүдийн биелэлтийг ханган ажиллах талаар холбогдох албан хаагчдад заавар, зөвлөмж өгсөн болно.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН  
ТАСГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙЦААГЧ



Ц.СОЛОНГО

Н.МӨНХЦОЛМОН